

Я.Ариунболд-ДХИС-ийн Удирдлагын академийн
Хилийн удирдлага стратеги профессорын багийн профессор, хурандаа
К.Алтанбек. ДХИС-ийн удирдлагын
академийн 8042 дугаар дамжааны
магистрант, хошууч
Ө. Ууганбаяр. ДХИС-ийн удирдлагын
академийн 8042 дугаар дамжааны
магистрант, хошууч

ХИЛИЙН ЦЭРГИЙН АНГИЙН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ МЭДЛЭГ, ЧАДВАР АЛБАНД НӨЛӨӨЛӨХ НЬ

Товчлол. Энэхүү өгүүлэлд Хил хамгаалах байгууллагын үүсэл, хөгжил, хөгжлийн явцад удирдлагаар хэрхэн хангаж , зохион байгуулж байсан, түүнийг хэрхэн төр засгаас дэмжиж прсэн талаар товч өгүүлнэ.

Түлхүүр үг:

Хил хамгаалах байгууллага
Хил хамгаалах байгууллагын түүхэн замнал
Хил хамгаалах байгууллагын удирдах албан тушаалтан,
менежментийн бодлого

Хүүрнэн өгүүлэх нь : Хил хамгаалах байгууллага нь Улс орны оршин тогтнох, аюулгүй байдлын баталгаа болсон нутаг дэвсгэр, түүний хил хязгаарыг чандлан хамгаалж, Олон Улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх, баталгаажуулах, Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах олон талт арга хэмжээг төрийн бодлогоор зохицуулж байдаг. Хил хамгаалах байгууллага халдашгүй дархан хилээ маш сайн хамгаалж байсан учраас өнөөдөр Монгол Улс энх амгалан амьдрач , ажиллаж байна. Энэ нь мартахын аргагүй түүхэн явц билээ.

Өргөн утгаар нь авч үзвэл хилийн аюулгүй байдлыг хангах, хил хамгаалалтыг зохион байгуулах үйл ажиллагааны эх сурвалж нь хилийн асуудлаар хууль тогтоомж, дүрэм, удирдамж, тушаалууд байх боловч энэ нь нийгмийн хөгжил, шаардлагыг зарим тал дээрээ хувирч өөрчлөгдөж байдаг ч эцэст нь хил хамгаалах ганцхан байдаг. Монгол Улсын туурга тусгаар тогтнолыг батлан хамгаалж байгаа цэргийн үйл ажиллагааны хамгийн чухал бөгөөд хариуцлагатай хэсэг нь түүнийг удирдан зохион байгуулах явц ба удирдлагын тогтолцоо гэж хэлж болно.

Удирдлага гэдэг нэр томъёо нь аливаа үйл ажиллагааг явуулахдаа түүний элементийг нэгтгэж үр нөлөө, үр ашиг, давуу тал тэр бүхнээр дүүрэн байх хар үгээр хэлбэл шалгарсан дарга, менежментийн бодлого билээ. Иймээс хилийн цэргийн удирдлага, зохион байгуулалт нь Монгол Улсын

Үндэсний аюулгүй байдлын гогцоо асуудал, түүнийг зохион байгуулах нь хэзээнээс нааш төрийн бодлого байж ирсэн.

Нөгөө талаас нь авч үзэхэд Улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлон хэрэгжүүлэх, иргэдийнхээ амгалан тайван аж төрөх аятай нөхцлийг хангах үүргийг аль ч улс оронд төр нь хэрэгжүүлдэг. Хэрэгжүүлэх алхмыг мэргэжлийн байгууллага тухайлбал Хил хамгаалах байгууллага гүйцэтгэдэг.

Өнөөдөр энх амгалан энхийг сахисан улс орнууд зэрэгцэн оршиж банья. Нэгэн үе тухайлбал Монгол Улс тусгаар тогтнолоо олж авах тухайн он жилүүдэд зэвсэгт хүчин газар шороогоо цусаараа, халуун амиараа тэмцэж олж хойч ирээдүй үедээ хүлээлгэн өгсөн нь цэргийн шилдэг удирдлагуудын гавьяа гэж хэлж болно. Дайн байлдааны үед баримталж байсан цэргийн удирдлагын зарчим нь өнөөдөр улам боловсронгуй болж хөгжсөн гэдэгтэй санал нэгдэнэ.

Дайн байлдааны үеийн цэргийн удирдлагын тактик нь хэрхэн ажиллаж байсныг дараах байдлаас харж болно.

Удирдлагын боломж: Тактикийн жижиг бүлгийн удирдлага нь үүрэг гүйцэтгэх явцад ахлах даргаас хамаарахгүй бүрэн биеэ даасан байдаг. Авсан байлдааны үүргийн хүрээнд ажиллагааг зохион байгуулах эрх бүлгийн удирдлага дээр төвлөрсөн байдаг. Дайсны дунд үүрэг гүйцэтгэх үед ажиллагаа амжилттай явагдах нь бүх хүний амь настай холбоотой байдаг учир байлдааныг зохион байгуулах ажилд бүх хүн санаа тавьж, энэ ажилд хамтын удирдлагын зарчмыг баримталдаг байна. Энэ нь бие даан үүрэг гүйцэтгэж байгаа жижиг бүлгийн удирдлагын давуу чанар болдог. Удирдлагын боломж нь бүлгийн бүх гишүүдийн байлдааныг зохион байгуулах мэдлэг, дадлага, чадвараар тодорхойлогдоно.

Дайсныг устгах боломж: Жижиг бүлгийн дайсныг устгах боломж нь бүлэг дайсныг галаар хөнөөх боломж, бүлгийн гишүүдийн байлдааны ур чадвар, гэнэтийн ажиллагааны чадвараар тодорхойлогддог. Бүлгийн галын боломж нь түүний орон тооны галын хэрэгслүүдийн галын боломжоор тодорхойлогдох тул жижиг бүлгийн хувьд хүч хэрэгсэл хязгаарлагдмал учир энэ нь давуу байдлыг илэрхийлж чаддаггүй. Харин бүлгийн гишүүдийн байлдааны ур чадвар, дайсны гэнэтийн цохилт өгөх боломж, газар орон, цаг улирлын нөхцлийг өөрт ашигтайгаар ашиглах чадвараар жижиг бүлгийн дайсныг устгах давуу чанар илэрдэг байна.

Бага хүчний дайсанд илрэгдэхгүй чанар нь түүнийг дайсанд гэнэтийн цохилт өгөх чадвартай болгох бөгөөд түүний энэ гэнэтийн ажиллагааны чанар жижиг бүлгийг давуу хүчтэй дайсныг устгах боломжтой болгодог. Иймд бүлгийн дайсныг устгах боломжийг тооцохдоо дараах үзүүлэлтүүдээр гаргах шаардлагатай байна. Үүнд:

- > Бүлгийн галын боломж
- > Гэнэтийн цохилт өгөх чадвар
- > Газар орны нөлөөлөл
- > Цаг агаар, улирлын нөхцлийг ашиглах чадвараар тооцно.

Ийм л арга тактикаар удирдаж эх орноо хамгаалсан байдаг байна. Тэгвэл өнөөдөр цэргийн удирдлага гэвэл өөр байдлаар ярих хэрэгтэй байх. Эдүгээ дэлхий дахинд даяаршлын үйл явц өрнөж, ардчилалын үзэл санаа түгэн дэлгэрч байгаа нь их, бага улс гүрэн бүрийн нийгмийн амьдралын бүх хүрээнд нөлөөлж, улс түмний харилцаанд бие биенийхээ тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хүндэтгэдэг чиг хандлага давамгайлж буй нь шинэ зууны өнгө төрхийг тодорхойлогч гол хүчин зүйл болж байна. Дэлхий дахины байдлыг шинэ зууны эхэн үед ийнхүү соёл, иргэншлийн дэвшил, хөгжлийг идэвхижүүлэгч хүчин зүйлүүд тодорхойлж байгаа боловч улс түмний нийтийн амгалан тайван байдлын тав тухыг алдагдуулж, олон түмний сэтгэлийг түгшээсэн хэрэг явдал гарсаар байгаа билээ.

Олон Улсын террорист халдлага, байгалийн элдэв гамшиг, үйлдвэрлэлийн осол, сүйрэл, өвчин тахал, хар тамхи, мансууруулах бодис болон зэр зэвсгийн хууль бус наймаа, шашин шүтлэг, ерөтнцийг үзэхүйн хэт туйлширлаас үүдэлтэй зэвсэгт мөргөлдөөн, дэлхийн бүс нутаг, түүний дотор Ази тивд багагүй уршиг тарьж, эрдэнэт хүний амь нас олноор үргэдэж, нутаг орноо орхин дайжих дүрвэгсэдийн тоо өссөөр л байна. Хүн төрөлхтөний эдгээр бэрхшээлийг даван туулахад улс орон бүрийн хүчин чармайлт онцгой чухал билээ.

Өвөг дээдсээс өвлүүлэн өгсөн Монгол Улсын тусгаар тогтнол бол Монголчуудын хамгийн үнэтэй, ариун нандин өв бөгөөд улс орныхоо тусгаар тогтнолыг хамгаалжи ирсэн уламжлалыг хадгалан үргэлжүүлэх нь манай төрийн үйл ажиллагааны гол чиглэл байсан, байсаар ч байх болно. Монгол Улс энэхүү үүргээ хэрэгжүүлэхдээ улс орны улс төр, нийгэм, эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдлаас үл хамааран төрийн бодлогын тэргүүлэх чанараа бүрэн хадгалж, төр засаг, нийт иргэдийнхээ эрх ашгийн тусын тулд үе улирлан мөрдөг чанарыг өөртөө агуулсан цэргийн удирдлагын бодлогыг тодорхойлж ирсэн байдаг.

Цэргийн удирдлагын тогтолцоо нь

Удирдлагын тогтолцоо түүнд тавигдах шаардлага ...

Захирагдсан анги (салбар)-уудын албаны бэлэн байдал, тэдний үүргээ биелүүлэх бүх талын бэлтгэл, түүнийг биелүүлэх явцад удирдлагаар хангах дарга (захирагч), штаб, удирдлагын бусад нэгжүүдийн чиглэл зорилготой, шаргуу үйл ажиллагааг удирдлага гэнэ.

Удирдлага тогтвортой, шуурхай, тасралтгүй, нууц байх шаардлагатай.

Удирдлага тогтвортой байх гэдэг нь улсын хилийн оператив тактикийн цагийн байдлын хүчин зүйлүүдийн нөлөөлөл бүхий нөхцөлд

удирдлага шуурхай, тасралтгүй, нууц хэвээр ажиллах чадвар юм. Удирдлагын тогтвортой байдлыг хангахын тулд:

- түүнийг хамгаалагдах болон сэргээгдэх чадварыг дээшлүүлэх,
- удирдлагын байрны өнгөлөн далдлалт болон инженерийн төхөөрөмжийг сайжруулах,
- удирдлагын хүч хэрэгслийн нөөцийг байгуулахад чиглэгдсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж хэрэгжүүлнэ.

Удирдлага шуурхай байх гэдэг нь тухайн цагийн байдлыг үнэлэн, шийдвэр гаргахад эсрэг талаас өрсөхөд оршино. Үүний тулд:

- удирдлагын байгууллага байнга бэлэн байх,
- түүний мэргэжлийн бэлтгэл өндөр түвшинд байх,
- удирдлагын тогтолцооны үүргийг бүтээмж сайн байх,
- тухайн цагийн байдалд цаг тухайд нь шийдвэр гаргах ба үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

Удирдлага тасралтгүй байх гэдэг нь дарга (захирагч)-аас захирагдсан анги (салбар)-ууддаа цаг тухайд нь үүрэг өгч тэднээс хилийн цагийн байдлын тухай мэдээллийг хүлээн авч, улсын хил хамгаалах үйл ажиллагааны явцад байнга нөлөөлөх чадвар юм. Удирдлага тасралтгүй байхын тулд дарга (захирагч) болон штабууд хилийн цагийн байдлыг байнга мэдэж, холбооны хэрэгсэл бүрэн бүтнээр үүргээ биелүүлэн, бие бүрэлдэхүүн удирдлагын тогтоосон дохиог мэдэж байх шаардлагатай.

Удирдлага нууц далд байх гэдэг нь онцгой байдлын үед дарга (захирагч) эсрэг талаас далд газарт байрлан удирдлагын дохио нууцлагдсан байх явдал юм. Удирдлагыг нууц байлгахын тулд удирдалгын байрыг маш сайн өнгөлөн далдалж радио болон утсан холбоог цогцолбороор хэрэглэн дохионы хэрэгслээр захирагдагсдаа чадварлаг удирдах шаардлагатай.

Удирдлагын тогтолцоо нь улсын хил хамгаалах төрийн захиргааны төв байгууллага, хилийн анги (салбар)-уудын удирдлагын зохион байгуулалт-техникийн үндсийг бүрдүүлнэ.

Удирдлагын тогтолцоо нь албаны бэлэн байдалтай, тогтвортой байх хэрэгтэй бөгөөд өөрийн орон тооны болог хүч нэмэгдүүлсэн анги (салбар)-уудыг идэвхитэй удирдах боломжтой, эсрэг талын мэдээллийн нөлөөллөөс найдвартай хамгаалагдсан байх шаардлагатай.

Удирдлагын тогтолцоо албаны өндөр бэлэн байдалтай байх гэдэг нь цагийн байдлын ямарч нөхцөлд ажиллахад удирдлагын байгууллага, хэрэгсэл байнга бэлэн байхыг хэлнэ. Үүний тулд удирдлагын байгууллагын бүрэлдэхүүн мэргэжлийн өндөр мэдлэгтэй, удирдлагын хэрэгсэл техникийн хувьд найдвартай байх шаардлагатай.

Удирдлагын тогтолцооны тогтвортой байдал нь цагийн байдлын ямарч нөхцөлд үүргээ өндөр бүтээмжтэй гүйцэтгэх явдлаар хангагдана.

Эсрэг талын мэдээллийн нөлөөллөөс хамгаалагдсан байх гэдэг нь дамжуулах ба хүлээн авах үйл ажиллагаанд мэдээллийг өөрчлөх зорилгоор эсрэг талын нөлөөллийг урьдчилан анхааруулах цогцолбор арга хэмжээнүүдийг хэлнэ.

Удирдлагын нэгжүүдийн ажлын уялдаа, штабуудын харилцан ажиллагаа

Удирдлагын үйл ажиллагааг амжилттай шийдвэрлэх чухал нөхцлийн нэг нь түүний нэгжүүдийн хоорондын ажлын уялдаа мөн.

Штабууд удирдлагын нэгжүүдийн уялдаа холбоотой, гар нийлэмжтэй ажиллагааг хангах ёстой. Тэр удирдлагын нэгжүүдийн үйл ажиллагааг бүрэн хэмжээгээр зохицуулж тэдний байнгын нягт холбоог тасалдуулалгүй ажлын гар нийлдсэн жигдрэлтийг хангах үүрэгтэй.

Штаб, удирдлагын нэгжүүдийн хоорондын харилцаа нь улсын хил хамгаалалтын арга хэмжээг хамтран боловсруулж хэрэгжүүлэх, анги (салбар)-уудын албаны бэлэн байдлыг хангах, тавигдсан үүргийг биелүүлэх нөхцлийг тэдэнд бүрдүүлэх, удирдлагын нэгжүүд, штабын дарга, офицерууд хоорондоо тогтмол биечлэн харьцах, хамтарсан арга хэмжээнд шаардагдах асуудлыг харилцан мэдээлэх явдалд тулгуурлагдана.

Штабуудын харилцан ажиллагаа гэдэг нь нэгдсэн нэг үүргийг биелүүлэх ашиг сонирхолд нийцүүлсэн тэдний гар нийлэмжтэй, хоорондоо зохицсон үйл ажиллагааг хэлнэ. Хаирлцан ажиллагааг хэрэгжүүлэх зарчим нь идэхитэй, тасралтгүй, чиглэл зорилготой байх, хүч хэрэгслийн зориулалт, боломжийг тооцоолж иж бүрнээр ашиглах зэрэг болно.

Харилцан ажиллагаа нь:

Штабуудын өгөдсөн үүргийг харилцан мэдэж түүнийг биелүүлэх үйл ажиллагаан ашигтай хувилбарыг тохиролцсноор,

-харилцан ажиллагааны агуулгыг тогмол тодотгосноор,

-дарга (захирагч), штабын дарга, удирдлагын бусад нэгжүүдийн хооронд нарийн зохион байгуулсан, байнга туслан дэмжсэн холбоо тогтоосноор тус тус хангагдана.

Удирдлагын зохион байгуулалт нь удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, цагийн байдлын ямарч нөхцөлд удирдлагын ажлыг байнгын бэлэн байдалд байлгах, мөн түүнчлэн түүний тасралтгүй ажиллагааг хангах арга хэмжээг бэлтгэж авахыг хэлнэ.

Удирдлагын үндэс нь дарга (захирагч)-ын шийдвэр байна.

Удирдлагыг зохион байгуулах үед дарга (захирагч)-ын шийдвэрийн үндсэн дээр штабууд:

-болох гэж буй ажиллагааны зорилго,

-үндсэн хүчийг төвлөрүүлэх чиглэл, улсын хил хамгаалалтын байгууламж,

-үйл ажиллагааг хэрэгжүүлэх цагийн байдал,

-захирагдсан анги (салбар)-уудыг удирдах удирдлагын хүч хэрэгсэл, холбооны байдал, тэдгээрийн боломж,

-хүч хэрэгслийн байдал,

-өгсөн үүргийг биелүүлэх үед анги (салбар)-уудыг удирдах онцгой шаардлагыг үнэлнэ.

Цаашид штабууд удирдлагын төлөвлөлтийг хэрэгжүүлж удирдлагын байр, холбооны шугам, зангилааг дэлгэж байрлуулах, удирдлагын цахим болон автоматжуулсан хэрэгсэл, тооцоолон бодох техникийг ажилд бэлтгэх, удирдлагын тогтолцооны найдвартай ажиллагааг хангах арга хэмжээг боловсруулна.

Удирдах ажилтны арга барил.

Ер нь цэргийн удирдах ажилтны ажлын арга барил нь хамгийн чухал асуудлуудын нэг юм. Цэргийн удирдлагын чанар, үр дүн, цэргийн удирдлагын байгууллагын албан тушаалтны ажлын арга барилаас шууд хамаарч байдаг. Удирдах ажилтны ажлын арга барил гэж захирагч, штабуудын хэвшин тогтсон буюу голлон хэрэглэж буй цэргийг удирдах арга туршлага, заншил, зуршлын нэгдлийг хэлэх бөгөөд энэ нь юуны өмнө удирдлага, зохицуулалтын хууль, зүй тогтол, зарчим, шаардлагад нийцэж байх¹ учиртай юм.

Нөгөө талаар цэргийн мэргэжлийн өндөр бэлтгэлтэй, зохион байгуулах авьяас чадвартай, сэтгэл зүйн хатуужилтай захирагч, дарга л ажлын шалгарсан тэргүүний арга барилыг эзэмшиж чадна. Мөн ажлын арга барилыг захирагч, дарга нарын цэргийг удирдах мэдлэг, туршлагаас гадна түүний хувийн зан чанартай холбон үздэг ч тал бий. Удирдагчийн хувийн зан чанар сул байх явдал нь цэргийн анги салбарын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх, цэрэг байлдагчийн сэтгэл зүйд муугаар нөлөөлж түүнээс гарах үр дагавар нийгэм цочоосон байхыг үгүйсгэх аргагүй юм.

Тухайлбал: би нэгэн жишээ дурьдъя. Сулинхээрийн ангид удаа дараа гарсан хүн амины хэрэг. Энэ нь дарга цэргээ дарамталсан, цэрэг дотроо оны ялгаагаар нэгнийгээ дарамталсан хар сүүдэр дагуулсан, эцэг эхийг өнчрүүлсэн түүхэн хар явдал болсон. Энэ бол ёс суртахууны хувьд удирдах ажилтан доголдох муу уршигтай гэдгийг харуулсан.

Цэргийн шинжлэх ухааны үсрэнгүй хөгжил, хөнөөх хэрэгсэл, тагнуул, холбоо, мэдээллийн техникийн байнгын шинэчлэл, тэдгээрийг нөхцөлдүүлсэн зэвсэгт тэмцлийн арга, тактикийн өөрчлөлт зэрэг нь цэргийн удирдлагын ара барилыг цаашид улам төгөлдөржүүлэхийг шаардах болов. Тэдгээрийн дотроос захирагч, дарга нар аливаа асуудлыг шийдвэрлэхдээ бүтээлчээр хандах, байнга шинийг эрэлхийх эрмэлзлэлтэй байх, шинжлэх ухааны үндэстэй хандаж байх шаардлага бол онцгой чухал болно.

Бүтээлч хандлага гэдгийг захирагч, дарга нарын гаргасан шийдвэр, баталсан төлөвлөгөөгөө амьдралд бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын оновчтой үйл ажиллагаа, зорилтдоо хүрэхийн төлөө саад бэрхшээлийг даван туулах чадвар, ажил асуудлын дундаас гол зангилааг олж барих мэдрэмж, эхэлсэн ажлаа эцсийн үр дүнд хүргэх уйгагүй зүтгэл гэж ойлговол зохино.

Эндээс харахад би нэг л зүйлийг хэлэх байна. Захирагч, дарга нар шинийг байнга эрэлхийлж, шинэ санаачлага, тэргүүн туршлага, дэвшилтэт аргыг цэргийн

¹ Ц.Дашзэвэг. Цэргийн удирдлагын үндэс.УБ., 2003.126 дахь тал

удирдлагын үйл ажиллагаандаа алхам тутамдаа нэвтрүүлж байх нь тэдний бүтээлч хандлагын үндэс байх болно гэдгийг хэлэх байна.

Ер нь цэргийг шинжлэх ухааны үндэслэлтэй удирдах гэдэг нь бүх шатны албан тушаалын захирагч, дарга нар :

Нэгдүгээрт: зэвсэгт тэмцлийн хуулиуд, тэдгээрийн үйлчлэх шинж чанар, хамрах хүрээг зөв танин мэдсэн байх

Хоёрдугаарт: орчин цагийн мэдээллийн технологид тулгуурлан цагийн байдлыг бүх талаас нь үнэлж, болитой тогтоож чаддаг байх

Гуравдугаарт: байгаль, нийгмийн болон техникийн шижнлэх ухааны дүгнэлт, зөвлөмжүүдийг цэргийн удирдах ажиллагаандаа авч ашиглаж чаддаг байх

Дөрөвдүгээрт: цэргийн удирдлагын аливаа үүргийг хэрэгжүүлэхдээ шинэчилсэн дэвшилтэт байдлыг байнга хэрэгжүүлж түүнд дүн шинжилгээ хийж байх гэх мэт.

Удирдагч хүнд хариуцлага гэж байх ёстой. Аливаа байгууллагад хүмүүсийн үйл ажиллагааг цэгцтэй явуулах хамгийн үндсэн нөхцөл нь хариуцлагын тодорхой тогтолцоо байдаг. Хариуцлага гэдэг¹ нь даалгасан үүргийн гүйцэтгэл гэж тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл удирдах албан тушаалтнаас хариуцлага харагдах явдал нь түүний албандаа хандах сэтгэл, зүтгэлээс хамааралтай. Удирдах ажилтан хичнээн өндөр мэдлэг, чадвартай байгаа ч түүнээс сэтгэл, зүтгэл гарахгүй бол тэр чадвар нь талаар өнгөрч салхинд хийсэнтэй адил болно.

Удирдагч хүнд нөлөөлөл гэж байх ёстой. Нөлөөлөл гэдэг нь удирдагч байгууллагын гишүүддээ өөрийн дур сонирголоор үүргээ үр дүнтэй, чанартай гүйцэтгэх эрмэлзлэл төрүүлэхийг хэлнэ. Удирдагч ийнхүү байгууллагын гишүүдэд идэвхи, эрмэлзлэл үүсгэснээр тэдний үйл ажиллагааг зохих зөв чиглэлд жолоодох боломжтой болдог байна. Зохих чиглэл гэж тухайн байгууллагын зорилтуудыг хангахад хөтлөх чиглэлүүдийг хэлж байгаа юм.

Эрмэлзлэл үүсгэх арга нь байгууллагын бүрэлдэхүүнийг өөрийнхөө дур зоргоор удирдан залах биш харин ямар эрмэлзлэлд хөтлөгдөн ажилладагийг танин мэдэж байх удирдан залах явдал гэж ойлгож болно.

Энэ бүгдээс үндэслээд эцэст нь зангидан хэлэхэд удирдлагын хэлбэр нь харилцааны нэгэн онцлог, цэргийн үйл ажиллагааны хувьд овун санаа, уураг тархи лутаа зохицуулан залагч, удирдан чиглүүлэгч, хянан шалгагч байхын зэрэгцээ удирдлагын мэдрэмж, хариу үйлдэл, шуурхай чанар нь түүний үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх үзүүлэлт байдаг. Өөрөөр хэлбэл удирдагч байхыг хүсч байгаа бол удирдлагын онолын мэдлэг, удирдахуйн урлагийг сайтар эзэмших нь чухал. Цэргийн сайн удирдагч байхын тулд цэргийн эрдэмд шамдан суралцаж асуудлыг цогц байдлаар шийддэж чаддаг сайн менежменттэй байх хэрэгтэй гэж үзэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Чадраабал.Л.Монгол үгийн тайлбар толь. УБ., 1999.
2. Дашдэлэг.Ц Цэргийн удирдлагын үндэс. УБ., 2003.
3. Монгол Улсын Цэргийн түүх -3-р дэвтэр. 1998.
4. Сүндэв.П Хил хамгаалах бодлого, үйл ажиллагаа.УБ., 2004 .

¹ Л.Чадраабал. Монгол үгийн тайлбар толь. УБ., 2000. 1251 дэх тал